



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/15

Шивээговь сум

**Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд  
 хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. XVII жарны Сайжруулагч хэмээх Усан бар жилийн Сар шинийн баярыг тохиолдуулан Улсын “Алдарт уяач”-аар шагнагдсан Гомбосүрэнгийн Адъяасүрэн, “Алтан төлийн эзэн”-ий болзол ханган шагнагдсан малчин Батсүхийн Отгонбаатар, аймгийн “Аварга малчин өрх”-өөр шалгарсан Батцэнгэлийн Хашхүү, Төмөрийн Энхзул нарт хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1,470,000 (нэг сая дөрвөн зуун далан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Б.Энхмаа), нярав (Д.Гантогтох) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ



42122110

Сумын Засаг даргын ...-ны ...-р  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт



ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨСӨВ

2022.02.01

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Монгол Улсын "Алдарт уяач"-д гарын бэлэг гардуулж, хүндэтгэл үзүүлэх /мөнгөн аяга, дурсгалын зүйл/	1	490,000	490,000
2	"Алтан төлийн эзэн"-д гарын бэлэг гардуулах /мөнгөн аяга, дурсгалын зүйл/	1	490,000	490,000
3	Аймгийн "Аварга малчин өрх"-д гарын бэлэг гардуулах /мөнгөн аяга, дурсгалын зүйл/	1	490,000	490,000
<b>Нийт</b>				<b>1,470,000</b>